



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/173/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Утас: 99862066 Цахим хаяг: peakomaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	Error! Bookmark not defined.
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/173-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМЫН
НОМГОН ТОСГОНЫ ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.МАРТ ТАНАА**

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	38,144,889.17	46,723,084.27
35	БАРАА МАТЕРИАЛ	38,144,889.17	46,723,084.27
35100	Түүхий эд материал	311,800.00	414,900.00
35130	Эм боох материал	311,800.00	414,900.00
35400	Хангамжийн материал	37,833,089.17	46,308,184.27
35420	Аж ахуйн материал	19,062,950.00	19,562,550.00
35450	Барилгын засварын материал	-	1,252,420.00
35470	Бусад хангамжийн материал	18,770,139.17	25,493,214.27
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	839,558,056.97	821,370,582.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	839,558,056.97	821,370,582.40
39200	Биет хөрөнгө	823,773,456.93	805,835,982.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	838,239,069.67	838,239,069.67
39202	Хуримтлагдсан элэгдэл	(83,215,839.54)	(123,402,658.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,562,499.68)	(14,562,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	70,649,617.00	91,428,117.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,875,430.87)	(49,694,507.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,262,731.40	53,815,731.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,617,047.92)	(36,757,319.58)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,358,055.37	36,358,055.37
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,027,698.50)	(4,150,505.49)
39300	Биет бус хөрөнгө	15,784,600.04	15,534,600.08
39301	Програм хангамж	1,768,000.00	1,768,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(767,999.96)	(1,017,999.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	14,784,600.00	14,784,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	877,702,946.14	868,093,666.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	21,508,048.00	2,738,898.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,508,048.00	2,738,898.00
41300	Өглөг	21,508,048.00	2,738,898.00
41360	Бусад өглөг	21,508,048.00	2,738,898.00
41361	Байгууллагад төлөх өглөг	21,508,048.00	2,738,898.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	856,194,898.14	865,354,768.67
51	Засгийн газрын хувь оролцоо	856,194,898.14	865,354,768.67
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	396,512,915.71	396,512,915.71
51200	Хуримтлагдсан үр дүн	(236,491,148.17)	(227,331,277.64)
51210	Өмнөх үеийн үр дүн	(232,227,421.69)	(236,491,148.17)
51220	Тайлант үеийн үр дүн	(4,263,726.48)	9,159,870.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	696,173,130.60	696,173,130.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	877,702,946.14	868,093,666.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	718,314,565.14	778,086,575.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,606,865.14	37,957,575.10
120	Нийтлэг татварын бус орлого	22,606,865.14	37,957,575.10
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	19,063,218.00	30,731,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,543,647.14	7,226,075.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	695,707,700.00	740,129,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	586,038,500.00	601,710,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	586,038,500.00	601,710,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	13,972,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	13,615,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	357,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	109,669,200.00	124,446,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	109,669,200.00	124,446,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	722,578,291.62	768,926,704.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	722,578,291.62	768,926,704.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	684,785,645.62	707,004,633.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	445,111,200.00	441,104,856.00
210101	Үндсэн цалин	273,643,500.00	271,023,683.00
210102	Нэмэгдэл	137,414,100.00	139,700,419.00
210104	Урамшуулал	34,053,600.00	30,380,754.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,715,014.00	57,253,543.00
210201	Тэтгэврийн даатгал	37,921,593.00	40,043,725.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,448,353.00	4,414,336.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,558,685.00	3,531,472.00
210204	Ажилгүйдлийн даатгал	889,671.00	842,180.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,896,712.00	8,421,830.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,684,412.00	104,231,350.00
210301	Гэрэл, цахилгаан	6,708,923.00	6,667,266.00
210302	Түлш, халаалт	77,555,969.00	86,791,124.00
210303	Цэвэр, бохир ус	9,419,520.00	10,772,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,465,700.00	5,137,300.00
210401	Бичиг хэрэг	213,000.00	430,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,230,000.00	600,000.00
210404	Ном, хэвлэл	192,900.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,550,800.00	2,044,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,646,000.00	962,120.00
210408	Бараа материал акталсны зардал	5,433,000.00	-
2105	Нормативт зардал	7,641,810.00	14,372,330.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,000.00	635,800.00
210502	Хоол, хүнс	7,581,810.00	13,736,530.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,131,100.00	17,044,880.00
210604	Урсгал засвар	4,131,100.00	17,044,880.00
2107	Томилолт, зочны зардал	1,462,800.00	831,000.00
210702	Дотоод албан томилолт	1,462,800.00	831,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	919,500.00	4,150,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	343,500.00	3,286,600.00

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	864,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,654,109.62	62,878,774.57
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,549,700.00	1,359,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,104,409.62	61,518,974.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,792,646.00	61,922,071.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,839,370.00	16,924,490.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,339,370.00	16,224,490.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	700,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,953,276.00	44,997,581.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,953,276.00	44,997,581.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(4,263,726.48)	9,159,870.53
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(4,263,726.48)	9,159,870.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	695,707,700.00	740,129,000.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
110	Орлогын албан татвар	-	-
1100	Хувь хүний орлогын албан татвар	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	695,707,700.00	740,129,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	586,038,500.00	601,710,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	586,038,500.00	601,710,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	13,972,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	13,615,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	357,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	109,669,200.00	124,446,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	109,669,200.00	124,446,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	675,057,700.00	727,529,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	675,057,700.00	727,529,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	637,647,054.00	665,606,929.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	445,111,200.00	441,104,856.00
210101	Үндсэн цалин	273,643,500.00	271,023,683.00
210102	Нэмэгдэл	137,414,100.00	139,700,419.00
210104	Урамшуулал	34,053,600.00	30,380,754.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,715,014.00	57,253,543.00
210201	Тэтгэврийн даатгал	37,921,593.00	40,036,158.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,448,353.00	4,414,336.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,558,685.00	3,531,472.00
210204	Ажилгүйдлийн даатгал	889,671.00	842,187.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,896,712.00	8,429,390.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,000,500.00	123,000,500.00
210301	Гэрэл, цахилгаан	6,708,923.00	6,667,266.00
210302	Түлш, халаалт	92,872,057.00	105,560,274.00
210303	Цэвэр, бохир ус	9,419,520.00	10,772,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,600,700.00	4,258,300.00
210401	Бичиг хэрэг	213,000.00	430,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,230,000.00	600,000.00
210404	Ном, хэвлэл	192,900.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,804,700.00	1,274,980.00

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,960,100.00	853,120.00
2105	Нормативт зардал	8,156,540.00	15,351,030.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	461,800.00	738,900.00
210502	Хоол, хүнс	6,980,740.00	13,736,530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	714,000.00	875,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,131,100.00	18,297,300.00
210604	Урсгал засвар	4,131,100.00	18,297,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,462,800.00	831,000.00
210702	Дотоод албан томилолт	1,462,800.00	831,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	919,500.00	4,150,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	343,500.00	3,286,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	864,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,549,700.00	1,359,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,549,700.00	1,359,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,410,646.00	61,922,071.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,457,370.00	16,924,490.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,957,370.00	16,224,490.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	700,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,953,276.00	44,997,581.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,953,276.00	44,997,581.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	20,650,000.00	12,600,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	20,650,000.00	12,600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,650,000.00	12,600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,650,000.00	12,600,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,650,000.00	12,600,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(20,650,000.00)	(12,600,000.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
14	Бусад эх үүсвэр	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,512,915.71	696,173,130.60	(232,227,421.69)	860,458,624.62
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	396,512,915.71	696,173,130.60	(232,227,421.69)	860,458,624.62
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(4,263,726.48)	(4,263,726.48)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,512,915.71	696,173,130.60	(236,491,148.17)	856,194,898.14
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	396,512,915.71	696,173,130.60	(236,491,148.17)	856,194,898.14
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	396,512,915.71	696,173,130.60	(236,491,148.17)	856,194,898.14
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	9,159,870.53	9,159,870.53
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	396,512,915.71	696,173,130.60	(227,331,277.64)	865,354,768.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	726,157,000.00	681,159,419.00	44,997,581.00	93.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	726,157,000.00	681,159,419.00	44,997,581.00	93.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	708,142,200.00	664,234,929.00	43,907,271.00	93.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	478,655,100.00	441,104,856.00	37,550,244.00	92.16
210101	Үндсэн цалин	331,872,700.00	271,023,683.00	60,849,017.00	81.66
210102	Нэмэгдэл	113,063,100.00	139,700,419.00	(26,637,319.00)	123.56
210104	Урамшуулал	33,719,300.00	30,380,754.00	3,338,546.00	90.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,800,900.00	57,253,543.00	3,547,357.00	94.17
210201	Тэтгэврийн даатгал	42,294,700.00	40,036,158.00	2,258,542.00	94.66
210202	Тэтгэмжийн даатгал	4,626,600.00	4,414,336.00	212,264.00	95.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,701,300.00	3,531,472.00	169,828.00	95.41
210204	Ажилгүйдлийн даатгал	925,300.00	842,187.00	83,113.00	91.02
210205	Эрүүл мэндийн даатгал	9,253,000.00	8,429,390.00	823,610.00	91.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	123,000,500.00	123,000,500.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	7,942,500.00	6,667,266.00	1,275,234.00	83.94
210302	Түлш, халаалт	103,809,400.00	105,560,274.00	(1,750,874.00)	101.69
210303	Цэвэр, бохир ус	11,248,600.00	10,772,960.00	475,640.00	95.77
2104	Хангамж, бараа материалын зардал	4,233,900.00	3,901,300.00	332,600.00	92.14
210401	Бичиг хэрэг	214,600.00	271,200.00	-56,600.00	126.37
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	800,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,000.00	600,000.00	500,000.00	54.55
210404	Ном, хэвлэл	300,000.00	300,000.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	727,400.00	1,076,980.00	(349,580.00)	148.06
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,091,900.00	853,120.00	238,780.00	78.13
2105	Нормативт зардал	17,214,100.00	15,351,030.00	1,863,070.00	89.18
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	738,900.00	738,900.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	15,599,600.00	13,736,530.00	1,863,070.00	88.06
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	875,600.00	875,600.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,282,300.00	17,282,300.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,600,000.00	12,600,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	4,682,300.00	4,682,300.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,445,000.00	831,000.00	614,000.00	57.51
210702	Дотоод албан томилолт	1,445,000.00	831,000.00	614,000.00	57.51
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,150,600.00	4,150,600.00	0.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,286,600.00	3,286,600.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,359,800.00	1,359,800.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,359,800.00	1,359,800.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,014,800.00	16,924,490.00	1,090,310.00	93.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,014,800.00	16,924,490.00	1,090,310.00	93.95
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,314,800.00	16,224,490.00	1,090,310.00	93.70

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	700,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	726,157,000.00	726,157,000.00	0.00	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	601,710,900.00	601,710,900.00	0.00	100.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	601,710,900.00	601,710,900.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	124,446,100.00	124,446,100.00	0.00	100.00
320001	Орон нутгийн төсвөөс	124,446,100.00	124,446,100.00	0.00	100.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	369.00	369.00	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	36.00	36.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	0.00	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	296.00	296.00	0.00	100.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬДСУРАЛЦАГЧИД	296.00	296.00	0.00	100.00
630001	Төрийн өмчит ЕБС	296.00	296.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	36.00	36.00	0.00	100.00
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	22.00	22.00	0.00	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00	0.00	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12.00	12.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	13,972,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	13,972,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	13,972,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	357,000.00
210401	Бичиг хэрэг	-	159,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	198,000.00
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	13,615,000.00
210604	Урсгал засвар	-	13,615,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	13,972,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	13,972,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	13,615,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	-	357,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Номгон тосгоны ерөнхий боловсролын сургууль гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримт бичигтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Пийк-Ом Аудит ХХК-ийн аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Номгон тосгоны ерөнхий боловсролын сургууль нь “Хүүхэд бүрийн суралцахуйг дэмжин үр дүнтэй суралцахад нь хамтран ажиллая” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа,
- Иргэнд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах босго үнийг “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Монгол улсын засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор шинэчлэн хийгдсэн гэх мэт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Номгон тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 722,578.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,225.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 5,058.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Номгон ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,609.3 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага			
Бараа материал	38,144.80	46,723.00	8,578.20
Үндсэн хөрөнгө	839,558.00	821,370.50	(18,187.50)
Нийт хөрөнгө	877,702.80	868,093.50	(9,609.30)
Өр төлбөр	21,508.00	2,738.80	(18,769.20)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	856,194.80	865,354.70	9,159.90
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	877,702.80	868,093.50	(9,609.30)

Бараа материалын дансны үлдэгдэл 46,723.0 мянган төгрөг болж 8,578.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 39,978.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар Жайка олон улсын байгууллагаас 169.0 мянган төгрөгийн ариутгалын бодис, аймгийн БСУГ-аас 334.0 мянган төгрөгийн маск, амны хаалт, 1,038.3 мянган төгрөгийн ном, сурах бичиг, Синапс ХХК-аас 5,684.8 биологи, лабораторийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авч, 38,626.2 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаанд зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,050,956.0 мянган төгрөг болж өмнөх оноос 43,311.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 12,600.0 мянган төгрөгийн принтер, компьютер худалдан авч, Синапс ХХК-аас 8,178.6 мянган төгрөгийн микроскоп, 3,533.0 мянган төгрөгийн 4 ширэмтэй цахилгаан зуух, иргэн Сундуйжав, Батмөнх нараас 19,000.0 мянган төгрөгийн хашааг тус тус хандиваар хүлээн авч үнэ төлбөргүй хүлээн авч, орлогоор бүртгэснээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,738.8 мянган төгрөг болж өмнөх оноос 18,764.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны дулааны төлбөрийг бүрэн барагдуулснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 865,354.70 мянган төгрөг болж 9,609.30 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 778,086.5 мянган төгрөг болж өмнөх оноос 59,772.0 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 28,965.7 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих орлого 15,672.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 768,926,7 мянган төгрөг болж өмнөх оноос 46,348.4 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн нь тогтмол зардал 10,546.9 мянган төгрөг, норматив зардал 6,730.5 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Номгон тосгоны сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 662,405.0 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 63,752.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 726,157.0 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр **726,157.0** мянган төгрөгийн төсөв баталснаас, 601,710.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 124,446.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 601,710.9 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 124,446.1 мянган төгрөг, нийт 726,157.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 681,159.4 мянган төгрөгийг зарцуулж, 44,997.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **618,159.4** мянган төгрөг буюу 93.8 хувьтай тайлагнагдсан нь цалин урамшууллын зардлыг 37,550.2 мянган төгрөгөөр, норматив зардлыг 1,863.0 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас ариутгал, бичиг хэргийн зардалд 357.0 мянган төгрөг, төгсөгчдөөс өгсөн 13,615.0 мянган төгрөгийн хандив зэрэг нийт 13,972.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 13,615.0 мянган төгрөгийг урсгал засварын зардалд, 189.0 мянган төгрөгийг хог хаягдал зайлуулах зардалд, 159.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд зэргээр зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3

дахь “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%” гэж заасан боловч сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, сургуулийн багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

3.7.2 БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын хоёрдугаар хавсралт “Короновируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд Номгон тосгоны сургуульд 726,157.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 618,159.4 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн

төлөвлөгөөг 6.2 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 ӨМНӨХ АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Тус сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/60 дугаар тушаалаар “Итгэмжлэл” олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 36,534.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 36,534.6 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ*” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:

2.1 Илрүүлэлт: Шилэн дансанд нийт мэдээлбэл зохих 149 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, 6.4 дахь заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны сургууль	2	36,534.6							2	36,534.6